БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хутаг-Өндөр сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/100/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр:

Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn


Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт.......................................................................................3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл...........................................4-15
3. Аудитын тайлан.........................................................................................15-18
   3.1 Ерөнхий зүйл.........................................................................................
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.......................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..............................................................
   3.4 Материаллаг байдал...................................................................................
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга......................................................................
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.........................................................
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг...............................................
   3.8 Аудитын гол асуудал....................................................................................
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.............
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.......................................................................
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.............................................................
4. Аудитын илрүүлэлт....................................................................................18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.............................................................19

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 75

танай ________ны № ________т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Д.ГАНЦОГТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:/bichighereg/2022A4toot

006020117

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,537,500.00** | **10,445,100.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 10,445,100.00 | 10,445,100.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 10,445,100.00 | 10,445,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,445,100.00 | 10,445,100.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **275,702,236.01** | **261,441,107.18** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 275,702,236.01 | 261,441,107.18 |
| **392** | **Биет хөрөнгө** | 273,114,235.97 | 258,875,107.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 585,476,401.71 | 585,476,401.71 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -354,414,887.15 | -364,172,827.19 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 21,281,540.00 | 12,496,140.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -9,500,064.56 | -9,522,140.08 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,683,818.00 | 15,106,718.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,735,563.26 | -8,496,907.34 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,870,554.60 | 21,537,559.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,367,475.37 | -7,369,749.00 |
| 39217 | Ном | 13,819,912.00 | 13,819,912.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 2,588,000.04 | 2,566,000.08 |
| 39301 | Програм хангамж | 220,000.00 | 220,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -21,999.96 | -43,999.92 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,390,000.00 | 2,390,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **286,239,736.01** | **271,886,207.18** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **713,935.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 713,935.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 713,935.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 713,935.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **286,239,736.01** | **271,172,272.18** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 286,239,736.01 | 271,172,272.18 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 94,515,463.37 | 94,515,463.37 |
| 51101 | Өмч: - төрийн | 94,515,463.37 | 94,515,463.37 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -93,394,345.99 | -108,383,209.82 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -93,394,345.99 | -93,315,745.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -15,067,463.83 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 285,118,618.63 | 285,040,018.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **286,239,736.01** | **271,886,207.18** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **124,796,600.00** | **107,893,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,335,000.00** | **500,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,335,000.00 | 500,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 16,335,000.00 | 500,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 500,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **108,461,600.00** | **107,393,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 107,961,600.00 | 102,393,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 107,961,600.00 | 102,393,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 500,000.00 | 5,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **124,347,325.52** | **121,616,520.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **124,347,325.52** | **121,616,520.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 118,310,364.00 | 121,215,765.79 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 52,859,691.48 | 52,204,535.00 |
| 210101 | Үндсэн цалин | 41,702,885.72 | 42,291,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 11,156,805.76 | 9,913,235.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,567,091.00 | 6,927,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,465,623.00 | 4,867,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 525,367.00 | 514,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 420,294.00 | 411,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 105,073.00 | 103,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,050,734.00 | 1,029,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,320,906.00 | 40,504,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 247,506.00 | 429,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,073,400.00 | 40,075,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 318,700.00 | 324,995.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 58,700.00 | 59,995.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 110,000.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 85,000.00 | 75,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 90,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 318,000.00 | 1,080,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 18,000.00 | 80,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 60,000.00 | 58,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 60,000.00 | 58,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,371,750.00 | 2,199,650.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,263,750.00 | 1,899,650.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,450,725.52 | 17,916,685.79 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,950,725.52 | 17,916,685.79 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,036,961.52 | 400,755.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,667,700.00 | 308,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 308,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 369,261.52 | 92,755.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 369,261.52 | 92,755.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **449,274.48** | **-13,723,020.79** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 9,483,064.02 | 1,344,443.04 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,121,564.02 | 1,344,443.04 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -9,483,064.02 | -1,344,443.04 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-9,033,789.54** | **-15,067,463.83** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,515,463.37** | **285,118,618.63** | **-93,394,345.99** | **00.00** | 286,239,736.01 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,515,463.37** | **285,118,618.63** | **-93,394,345.99** | **00.00** | 286,239,736.01 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 78,600.00 | 00.00 | 78,600.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **94,515,463.37** | **285,118,618.63** | **-93,315,745.99** | **00.00** | 286,318,336.01 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -78,600.00 | 00.00 | 00.00 | -78,600.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -15,067,463.83 | 00.00 | -15,067,463.83 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **94,515,463.37** | **285,040,018.63** | **-108,383,209.82** | **00.00** | 271,172,272.18 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **108,461,600.00** | **107,985,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **592,400.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 592,400.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 592,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 500,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 92,400.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **108,461,600.00** | **107,393,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 107,961,600.00 | 102,393,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 107,961,600.00 | 102,393,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 500,000.00 | 5,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **108,461,600.00** | **102,985,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **108,461,600.00** | **102,985,900.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **102,424,638.48** | **102,585,145.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 52,859,691.48 | 51,490,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 41,702,885.72 | 42,291,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 11,156,805.76 | 9,199,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,567,091.00 | 6,927,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,465,623.00 | 4,867,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 525,367.00 | 514,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 420,294.00 | 411,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 105,073.00 | 103,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,050,734.00 | 1,029,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,320,906.00 | 40,504,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 247,506.00 | 429,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,073,400.00 | 40,075,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 314,200.00 | 324,995.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 58,700.00 | 59,995.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 110,000.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 85,000.00 | 75,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 90,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 390,000.00 | 1,080,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 90,000.00 | 80,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 60,000.00 | 58,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 60,000.00 | 58,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,371,750.00 | 2,199,650.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,263,750.00 | 1,899,650.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,036,961.52** | **400,755.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,667,700.00 | 308,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 308,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 369,261.52 | 92,755.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 369,261.52 | 92,755.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **5,000,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **5,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **5,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 5,000,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 00.00 | 5,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-5,000,000.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 00.00 | 00.00 | 102,893,500.00 | 102,893,145.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 102,893,500.00 | 102,893,145.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 00.00 | 00.00 | 102,585,500.00 | 102,585,145.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 00.00 | 00.00 | 51,490,600.00 | 51,490,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 00.00 | 00.00 | 42,291,300.00 | 42,291,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 00.00 | 9,199,300.00 | 9,199,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 00.00 | 00.00 | 6,927,100.00 | 6,927,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 00.00 | 4,867,500.00 | 4,867,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 514,900.00 | 514,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 00.00 | 411,900.00 | 411,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 103,000.00 | 103,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 1,029,800.00 | 1,029,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 00.00 | 40,504,800.00 | 40,504,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 00.00 | 429,600.00 | 429,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 00.00 | 40,075,200.00 | 40,075,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 00.00 | 325,000.00 | 324,995.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 00.00 | 60,000.00 | 59,995.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 00.00 | 100,000.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 00.00 | 75,000.00 | 75,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 90,000.00 | 90,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 00.00 | 1,080,000.00 | 1,080,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 00.00 | 80,000.00 | 80,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 00.00 | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 00.00 | 58,000.00 | 58,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 00.00 | 58,000.00 | 58,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 00.00 | 2,200,000.00 | 2,199,650.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 00.00 | 1,900,000.00 | 1,899,650.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 | 300,000.00 | 300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 0.00 | 308000.00 | 308000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 308,000.00 | 308,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 00.00 | 308,000.00 | 308,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 00.00 | 00.00 | 102,893,500.00 | 102,985,900.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 102,393,500.00 | 102,393,500.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 00.00 | 00.00 | 102,393,500.00 | 102,393,500.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 00.00 | 500,000.00 | 592,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 | 500,000.00 | 500,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 | 00.00 | 92,400.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 00.00 | 00.00 | 1,020.00 | 58,301.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 00.00 | 00.00 | 555.00 | 7,878.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 00.00 | 00.00 | 455.00 | 4,545.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | 00.00 | 10.00 | 45,878.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хутаг-Өндөр сумын Соёлын төв нь “Монгол Улсын жишиг соёлын төв болох” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд үйл ажиллагаа явуулж дараах “Ард иргэдийг соён гэгээрүүлж соёлын түгээх” байдлаар зорилт тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 133830.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2007.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1405.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Хутаг-Өндөр сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг /

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Урьдчилж гарсан зардал | | | |
| Авлага | 92.4 | 92.4 | 0 |
| Бараа материал | 10445.1 | 10445.1 | 0 |
| Үндсэн хөрөнгө | 652742.2 | 651046.7 | 1695.5 |
| **Нийт хөрөнгө** | **286239.7** | **271886.2** | **14353.5** |
| **Өглөг** | **0** | **713.9** | 713.9 |
| Хуримтлагдсан үр дүн | -93394.3 | 176656.8 | 83262.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 286239.7 | 271886.2 | 14353.5 |

**Авлага:** Өмнөх оны авлага буюу оны эхний үлдэгдэл 92.4 сая төгрөг, тайлант онд 92.4 сая төгрөгийн ажилчдтай холбоотой авлагыг барагдуулж тайлант онд эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 10.445,1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10.445,1 сая төгрөг болсноор өссөн буурсан үзүүлэлт гараагүй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бичиг хэрэг, аж ахуйн материал, түлш шатахуун, засварын материалыг 1964.6 сая төгрөгийн худалдан авалт хийж орлогоор тусгасан байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 65.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 65.1 сая төгрөг болж өмнөх оноос 1.6 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5.0, бусдаар 6.2 сая төгрөг нийт 11.2 сая төгрөгийн худалдан авалт хийжээ. Тайлант онд 62.1 сая төгрөгийг шилжүүлж, 6.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байна.

**Өр төлбөр:** Өглөгийн дансанд оны эхний үлдэгдэлгүй боловч тайлант онд 52.2 сая төгрөгийн ажилчдтай холбоотой өглөг үүснээс 51.5 сая төгрөгийг өглөгийг барагдуулж 0.7 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлгүй байна.
Санхүү байдлын, орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлага зэргийг тодруулж тайлагнасан болно.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хутаг-Өндөр сумын Соёлын төв нь 2021 онд орон нутгийн төсвөөс 99693.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөг буюу нийт 100193.53 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Хутаг-Өндөр сумын Соёлын төв нь 2021 он улсын төсвөөс 102985.9, нэмэлт дансаар 5000.0, өөрийн орлогоос 592.4 мянган төгрөг буюу нийт 107945.9 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 102893.4 мянган төгрөгийг зарцуулж 92.7 мянган төгрөгийг төвлөрүүлж тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хутаг-Өндөр сумын Соёлын төв нь 2021 онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс нэмэлт дансаар нийт 5000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч номын сангийн тавилга эд хогшилд тус тус зарцуулсан байна.
Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс олгосон 5000.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар

тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг зөрчсөн байна.

Мөн тайлант онд ажилчдтай холбоотой буюу цалингийн сан хүрээгүй улмаас 713.9 мянган төгрөгийн өглөг үүсэж байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба 8 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд
үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч хугацаа хоцроож мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 2 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 1/738 дугаартай албан тоотоор хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ажилчдын илүү цагийн бүртгэл, нэгтгэлтэй холбоотой анхан шатны баримтын бүртгэлийг архивлаж үдээгүй, цэгцгүй учраас анхаарал татахуйц байна. Иймд цалин, илүү цагийн нэмэгдлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5792.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 78.6 мянган төгрөгийн зөрчилд 1 залруулга, 5000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 713.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайлангаар 78,600 төгрөг зөрсөн нь өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүн дээр бичигдээгүй байсныг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Төсвийн хөрөнгөөр 5000,000 төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:
Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Өглөгийн данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд ажилчидтай холбоотой буюу цалингийн сан хүрээгүй тул 713.9 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтуудыг мөрдлөг болгож ажиллах.

**2. Шилэн данстай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт:

Тайлант онд Хутаг-Өндөр сумын Соёлын төв нь нийт 148 мэдээлэл мэдээлэхээс 8 мэдээлэл хоцроож мэдээлсэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь хоцроохгүй, хуулийн хугацаанд мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мян/төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хутаг-Өндөр сумын Соёлын төв | 4 | 5792.5 | 1 | 78.6 | 0 | 0 | 1 | 5000.0 | 2 | 713.9 |